

**НЦҮТ/ТХБ<sup>1</sup>-НЫ ДУНД ТӨСӨЛ ШАЛГАРУУЛАХ ЗАРЫН ДАГУУ ИРСЭН  
ТОДРУУЛГЫН ХАРИУ**

№ 2

2021 оны 5-р сарын 17

| № | Төсөл ирүүлэгчийн асуулт   | НҮБ-ын Хүн амын сангийн хариулт  |
|---|--|--|
| 1 | Хамгийн багадаа 6 сар тасралтгүй үйл ажиллагаа явуулсан байх? гэсэн шаардлагыг Түр хамгаалах байртай холбоотой гэж ойлгож байна. Үүнийг яаж нотлох вэ?   | Тийм. Тухайн Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байр байгуулагдаад үйл ажиллагаагаа дор хаяж 6 сар явуулсан байх ёстой. Анх байгуулагдсан тушаал, жил бүрийн батлагдсан төсөв, үйл ажиллагааны тайлан, үйлчилсэн хүний тоо зэргээр үйл ажиллагаа тогтвортой явуулж байгаагаа нотлох боломжтой. |
| 2 | Хууль ёсны статустай улсын бүртгэлтэй байх? /Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын улсын бүртгэлийн гэрчилгээ гэж ойлгож байна зөв үү?<br>Манай түр хамгаалах байр аймгаасаа санхүүжигдэж Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын харьяанд байдаг. | Тухайн НЦҮТ, ТХБ ямар байгууллагад харьяалагддаг, бүртгэлтэй гэдгээсээ хамааран явуулна. Энэ тохиолдолд аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын газрын тодорхойлолт албан бичиг ирүүлж болно. Өргөдлийн маягт дээр харьяа байгууллагыг асуусан байгаа.  |
| 3 | Ирүүлсэн төслийнхөө хяналт тайлагналт зэргийг гардан хариуцагч байна гэдэг нь ямар хүн байх вэ?  | Тухайн төслийг өргөдөл гаргагч ТХБ, НЦҮТ нь өөрийн дотоод нөөц, ажилтнуудад тулгуурлан бүрэн хариуцан хэрэгжүүлэх ба өөр гүйцэтгэгчид тухайн ажлыг хариуцуулахгүй.   |
| 4 | Өргөдлийн маягт нь өөрөө төсөл гэсэн үг үү, аль эсвэл тусдаа маягтаасаа гадна дахин төсөл бичээд хавсаргаж явуулах ёстой гэсэн үг үү?  | Тийм. Өргөдлийн маягт дээр байгаа асуултын дагуу мэдээллээ, төлөвлөгөөгөө үгийн хязгаарт багтаан оруулна. Харин нэмэлт хавсаргах материалуудаа (ажилчдын анкет зэрэг) хавсарган тусад нь явуулж болно.   |

<sup>1</sup> НЦҮТ/ТХБ – Нэг Цэгийн Үйлчилгээний Төв/Түр Хамгаалах Байр